

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага.

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (цаашид “ФАТФ” гэх)-ын 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалтаас гаргасан хэдийн боловч манай улс нь ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах үүргийг хүлээсэн хэвээр байгаа.

“Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 19/15 дугаар зөвлөмжид ФАТФ-ын зөвлөмжийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллахаар тусгасан.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-ын Зөвлөмж 15-д 2018 оны 10 дугаар сард орсон өөрчлөлтөд тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь “виртуал хөрөнгөнд” нэгэн адилаар үйлчлэхээр тогтоож, ФАТФ-ын хүлээн зөвшөөрсөн нэр томьёонд “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” нарыг тодорхойлсон.

Энэхүү тодорхойлолтоор виртуал хөрөнгө гэдэгт тархмал бүртгэлийн технологид суурилсан криптовалютыг хамруулж байна. Өөрөөр хэлбэл дижитал хэлбэрээр арилжих, шилжүүлэх боломжтой бөгөөд төлбөр, тооцоо мөн хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох үнэ цэнэ бүхий дижитал буюу биет бус хөрөнгийг виртуал хөрөнгө гэж тодорхойлж байна.

Дээрх тодорхойлолтын хүрээнд дэлхийн хөгжингүй улс орнууд өөрсдийн хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж виртуал хөрөнгийн зохицуулалттай болж эхэлсэн. Тухайлбал, Европын холбооноос “Мөнгө угаахтай тэмцэх 5 дахь удирдамж” - (The Fifth Money Laundering Directive - 5AMLD) гаргаснаар гишүүн орнууд өөрсдийн Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулж, виртуал хөрөнгийн зохицуулалтыг тусгах шаардлагатай болсон байна.

Олон улсад хэрэглэгдэж эхлээд байгаа энэхүү хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх, мөн үзүүлэгчдэд зөвшөөрөл олгох, хяналт тавих механизм, эрх зүйн орчин Монгол Улсад байхгүй байна.

Энэхүү виртуал хөрөнгө нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд тодорхойлсон цахим мөнгөний шинжийг агуулдаггүй. Өөрөөр хэлбэл Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар энэ хөрөнгө, түүний үйлчилгээ, зөвшөөрөл олголттой холбоотой харилцааг зохицуулдаггүй болно.

Монголбанкнаас бүх төрлийн криптовалютыг төлбөрийн хэрэгсэл гэж үздэггүй бөгөөд зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй.

Харин блокчэйн технологид суурилсан криптовалютыг Монгол Улсад бараа, үйлчилгээний төлбөрт одоогоор ашигладаггүй бөгөөд иргэд харин арилжааны хэрэгсэл болгон олон улсад болон дотоодод ашиглаж байна. Цаашид энэ хүрээгээ тэлж хөрөнгө оруулалт, төлбөрийн нэг төрөл болон өргөжих боломжтой юм.

Монгол Улсад криптовалютын арилжаа хийдэг хэд хэдэн цахим хуудас, нэг АТМ байгаа бөгөөд үүнтэй холбоотой үйлчилгээ нь Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх, төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг аль нэг байгууллагын хяналт, зохицуулалт дор байдаггүй. Энэ нь зөвхөн санхүүгийн хэрэглэгч өөрийн сонголтын хүрээнд биткойн арилжаа болон цахим хуудсаар дамжуулан криптовалютыг биржийн зарчмаар арилжаалж байна.

Өөрөөр хэлбэл дуудлага худалдаа арилжааны зарчим, зах зээлийн зарчим буюу эрэлт нийлүүлэлт, арилжаанд оролцогчийн хариу үйлдэл дээр тулгуурлан явагдаж байна.

Монгол Улсад дээрх хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явагдаж, иргэд, хуулийн этгээд оролцож байгаа нь энэ төрлийн эрх зүйн орчныг нэн яаралтай бүрдүүлэх шаардлагыг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл виртуал хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчин бүрдээгүй үед иргэн, хуулийн этгээд виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхэлж байгаа нь Монгол Улсыг болон тухайн харилцаанд оролцогч нарыг эрсдэлд оруулж байгаа бөгөөд мөнгө угаах болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлийг бий болгох зэрэг сөрөг үр дагавар их байна.

Хэдийгээр Монгол Улс нь 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт “саарал жагсаалт”-аас гарсан боловч ФАТФ-ын 15 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлж, виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байгаа болно.

Эдгээр хууль зүйн үндэслэл болон практик шаардлагад тулгуурлан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг Хууль, тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн зорилт нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох этгээдийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Харин Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгө, бусад улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэрийг ашиглах, гүйлгээнд оруулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

Түүнчлэн виртуал хөрөнгийн үйлчилгээнээс учирч болох эрсдэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцлээс үүсэх маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахгүй болно. Өөрөөр хэлбэл энэ төрлийн харилцаа нь Иргэний хуулиар зохицуулагдах харилцаа юм.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

- Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлно;

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны зарчим, тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулах нийтлэг болон нэмэлт шаардлагыг тодорхойлно. Нийтлэг шаардлагыг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар тодорхойлох бол нэмэлт шаардлагыг тухайн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих байгууллага тодорхойлохоор зохицуулна;

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, хяналтын механизмыг бүрдүүлнэ;

- Энэ харилцаанд оролцогчийн эрх үүргийг тодорхойлно;

- Виртуал хөрөнгө, түүнийг зарж борлуулсан, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлснээс олсон орлогоос татвар оногдуулах, харин тухайн үйлчилгээ үзүүлэгчийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгэн адил Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бий болгоно;

- Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар , үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна.

- Виртуал хөрөнгө, түүгээр үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрх зүйн орчин бий болно;

- Монгол Улс нь ФАТФ-ын стандарт, зөвлөмжийг биелүүлж, олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүнд өснө;

- Эдийн засгийн эргэлт нэмэгдэж, гадаад улсын хөрөнгө оруулагч нарыг татах нөхцөл бүрдэнэ;

- Виртуал хөрөнгөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр үндсэн шаардлагуудыг биелүүлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар.

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---o0o---